



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.БАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2017.10.04 № 01/7072
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт” нэмэлтээр орсон.

Мөн дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10^{1.3} дахь хэсэгт “Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг олон улсын эдийн засаг, банк санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан Монгол банк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас тогтооно” гэж заасны дагуу Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 244 дүгээр тогтоолоор баталсныг 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр тус газарт албан ёсоор ирүүлсэн байна.

Иймд Авлигын эсрэг хуулийн Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь “ЗӨВЛӨМЖ”-ийг хүргүүлж байна:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10^{1.1} дэх хэсэгт “хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно” заасны дагуу мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд болох нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн албан тушаалтныг албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахгүй байх;

2. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10^{1.2} дахь хэсэгт “холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсэн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу сонгогддог болон сонгуулийн үр дүнд

013943

томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол өөрийн удирдах болон томилох болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэж бүртгүүлэх;

3. Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд 3 сарын дотор нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээг авч, хөрөнгө, орлогын мэдүүлэгт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдэгдэж, шинэчлэн бүртгүүлэх;


4. Мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банкинд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах нь мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10¹.1-д хамаарахгүй бөгөөд харин албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт дээрх зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэж бүртгүүлэх;

Түүнчлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийн дагуу өөрийн болон харьяа салбар, нэгж байгууллагын мэдүүлэг гаргах үүрэгтэй, хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудад хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар зохих мэдээлэл хүргэж, хавсралтад дурдагдсан оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолтыг зөрчихгүй байх, хуулийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.


Хуульд орсон нэмэлт, өөрчлөлт болон Засгийн газраас баталсан оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг хавсралтаар тус тус хүргүүлэв.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 сарын 13 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 10¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"10¹ дүгээр зүйл. Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт

10¹.1. Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.

10¹.2. Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй.

10¹.3. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

10¹.4. Энэ хуулийн 10¹.2 дахь хэсэгт заасан нэр дэвшигч албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 244


Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10^{1.3}-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглох оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан шинэчлэн тогтоох асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

ОФФШОР БҮСЭД ХАМААРАХ ГАДААД УЛС,
ТҮҮНИЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЖАГСААПТ

Нэр (Монгол хэл дээр)	Нэр (Англи хэл дээр)
1. Ангиль	Anguilla
2. Андorraгийн Хант Улс	Andorra
3. Антигуа	Antigua
4. Аруба	Aruba
5. Барбадос Улс	Barbados
6. Баруун Индийн арлууд (Их Британи)	West Indies
7. Самоагийн Тусгаар Улс	Independent State of Samoa
8. Бахамын арлууд	Bahamas
9. Бахрейны Хаант Улс	Bahrain
10. БелизУлс	Belize
11. Бермудын арал	Bermuda
12. Британийн Виржинийн арлууд	British Virgin Islands
13. Бүгд Найрамдах Вануату Улс	Vanuatu
14. Бүгд Найрамдах Жибути Улс	Djibouti
15. Бүгд Найрамдах Кипр Улс	Cyprus
16. Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Costa Rica
17. Бүгд Найрамдах Либериа Улс	Liberia
18. Бүгд Найрамдах Ливан Улс	Lebanon
19. Бүгд Найрамдах Мавритан Улс	Mauritius
20. Бүгд Найрамдах Науру Улс	Nauru
21. Бүгд Найрамдах Панам Улс	Panama
22. Бүгд Найрамдах Уругвай Улс	Uruguay
23. Гернси	Guernsey
24. Гибралтар	Gibraltar
25. ГренадУлс	Grenada
26. Гуам	Guam
27. Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Dominica
28. Жерси	Jersey
29. Кайманы арлууд	Cayman Islands
30. Куукийн арлууд	Cook Islands
31. Лихтенштейний Вант Улс	Liechtenstein
32. Мадейра	Madeira
33. Марианы арлууд	Marianas
34. Бүгд Найрамдах Мальта Улс	Malta
35. Маршаллын арлууд	Marshall Islands
36. Холбооны Микронез Улс	Micronesia
37. Монакогийн Хант Улс	Monaco
38. Монтсеррат Улс	Montserrat
39. Мэний арал	Isle of Man
40. Нидерландын Антилийн арлууд	Netherlands Antilles
41. Ниуэ	Niue
42. Пуэрто Рикогийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Puerto Rico
43. Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс	Seychelles
44. Сент-Винсент-Гренадин Улс	St. Vincent and Grenadines
45. Сент-Китс-Невисийн Холбооны Улс	St. Kitts and Nevis
46. Сент-Люси Улс	St. Lucia
47. Танжер хот (Морокко)	Tangier
48. Тахити	Tahiti
49. Тёркс-кайкосын арлууд	Turks and Caicos Islands

байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол 3 сарын дотор дараахь арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ:

10¹.4.1. нээлгэсэн банкны дансаа хаалгах;

10¹.4.2. банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах;

10¹.4.3. хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах,

10¹.4.4. хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох.

10¹.5. Албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд энэ хуулийн 10¹.1 дэх хэсэг хамаарахгүй. Хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэнэ.

10¹.6. Энэ хуулийн 10¹.2, 10¹.4 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсч болзошгүйд тооцох үндэслэл болохгүй.

10¹.7. Энэ хуулийн 10¹.1, 10¹.2, 10¹.4, 10¹.5 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь албан тушаалтныг эгүүлэн татах үндэслэл болно.”

2 дугаар зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх заалтын “11,” гэсний өмнө “10¹.1, 10¹.2, 10¹.4, 10¹.5 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД